



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/171

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэнд, Боловсрол, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар болон багийн нийгмийн ажилтнуудад салбар хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх, соён гэгээрүүлэх, нийгмийн ажлын үйлчилгээний цар хүрээг өргөжүүлэх, харилцан туршлага солилцох, тулгамдаж буй асуудлаа тодорхойлох зорилготой хэлэлцүүлэг, зөвлөлдөх уулзалтын зардалд 2 000 000 төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 2 000 000 төгрөг /Хоёр сая/-ийг орон нутгийн хөгжлийн сангийн төсөл, арга хэмжээний 5.20-д тусгагдсан "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгааллыг дэмжих" хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ -д зөвшөөрсүгэй.


3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2019 оны 3 дугаар  
сарын 20- ны өдрийн А/171 дүгээр  
захирамжийн хавсралт



САЛБАРУУДЫН НИЙГМИЙН АЖИЛТНУУДЫН  
ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТЫН ТӨСӨВ

д/д	Материалын үнэ	Тоо ширхэг	Нэгжийн үнэ /төг/	Нийт үнэ /төг/	Хариуцах газар
1	Багц гарын авлага материал хэвлүүлэх	64	10000	640000	АЗДТГ
2	Дурсгалын зураг	67	3000	200000	АЗДТГ
3	Хавтас	64	2500	160000	АЗДТГ
4	Үдийн хоол	64	10000	640000	АЗДТГ
6	Үдийн цай	70	2000	140000	АЗДТГ
7	Дэвтэр, бал	55	5000	220000	АЗДТГ
	Нийт			2000 000 төгрөг	

-оОо-